



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 5/57

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн харуул хамгаалалтын ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Бямбадорж /Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэргэжилтэн/

Нарийн бичиг: Ц.Одончимэг /Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд: Ч.Тунгалаг /Захиргаа, санхүү, дотоод хяналтын албанд нярав/

Э.Бүжмаа /Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэргэжилтэн/

Д.Дондогмаа /Хөгжлийн төлөвлөлт, хамтын ажиллагааны албаны мэргэжилтэн/

2. Дээрх худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгохыг үнэлгээний хорооны дарга /Д.Бямбадорж / -д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны дарга /Л. Оюунчимэг/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.СОДНОМЖАМЦ

